

**2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ, ДЭД БҮТЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧООС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 08 дугаар 07

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
Үүрэг даалгавар НЭГ. Нийслэлийн Засаг даргын 2025 оны Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай А/934 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж, төлөвлөсөн ажлаа эрчимжүүлж ажиллах.				
1	Нийслэлийн Засаг даргын 2026 оны “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай” А/934 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж дүүрэгт хамаарах 6 ажлын биелэлтийг 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 03/2197 тоот албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.			50
Үүрэг даалгавар ХОЁР. Өвөлжилтийн үед хүндрэл гарч болзошгүй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, халаалтын зуух, бусад барилга байгууламжийн цахилгаан, дулаан, шугам сүлжээний засварын ажилд шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоо, судалгааг яаралтай гаргаж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах.				
2	Өвөлжилтийн үед хүндрэл гарч болзошгүй 4 эрүүл мэндийн байгууллагын 3 төрлийн засвар үйлчилгээний 105,377,000 төгрөг, 25 цэцэрлэгийн 53 төрлийн засвар үйлчилгээ 3,869,869,000 төгрөг, 7 сургуулийн 12 төрлийн засвар үйлчилгээний 1,736,300,000 төгрөгийн судалгааг гарган 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 03/2197 тоот албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.			100
Үүрэг даалгавар ГУРАВ. Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах авто замын шар тэмдэглэгээ, хурд сааруулагч, анхааруулга, санамж бүхий тэмдгүүдийг 09 дүгээр сарын 01-ний дотор байршуулж, засварлаж дуусгах.				
3	Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор авто замын шар тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, анхааруулга, санамж бүхий тэмдгүүдийг мэргэжлийн байгууллагаар шаардлагатай газруудад байршуулж, засварлах ба сургууль, цэцэрлэгүүд өөрсдийн хашааны доторх тэмдэг, тэмдэглэгээг урсгал			50

	засварын хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хийж гүйцэтгэх үүрэгтэйгээр чиглэл өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		
	Үүрэг даалгавар ДӨРӨВ. Авто замын гэрэлтүүлэг болон гэрлэн дохио хяналтын телекамерийн гэмтлийг тухай бүр нь шуурхай засварлаж, замын хөдөлгөөний хэвийн үйл ажиллагааг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.		
4	Тайлант хугацаанд 8 дугаар хороонд 107 камерт ус, чийгээс хамгаалах хамгаалалт болон шонгоос камерыг хөндийрүүлэх цэнхэр суурийг угсарч, суурилуулах, камеруудын линзүүдийг арчиж, цэвэрлэх ажлыг хийсэн. Мөн хороонд 3 цэгийн хайрцагны тогийг тасалсан байсныг засварлан шинээр кабель татаж холбон хэвийн ажиллагаанд оруулсан. Дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6 дугаар хороодын камер дамжуулах хайрцгуудад үзлэг хийж шилэн кабель болон цахилгааны утас тасарсан, свич, медиа конвектор шатсан, STP кабель гэмтсэн байсныг тухай бүрд нь засварлан ажилласнаар 1-6 дугаар хороодын камерын гаралтыг 80-аас дээш хувьд хүргэсэн. Дүүргийн 17 дугаар хорооны 72 дугаар гудамжны худгийн хажуугийн шонгийн камерын утас унжсан дуудлагын дагуу шаардлагатай засварыг хийж доголдлыг арилгасан.		90
	Үүрэг даалгавар ТАВ. Нийтийн эзэмшлийн зам, талбайн халтиргаа, гулгааг арилгах тусгай зориулалтын бодис, элс, давсыг хангалттай нөөцөлж, стандартын дагуу агуулах, сав бэлтгэх.		
5	Чингэлтэй тохижилт үйлчилгээ ХХК, Найши трейд ХХК нь өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган цас хайлуулах давс 2500тн, бодис 2250тн, хайрга дайрга 150м3 нөөцөлсөн. Өгсүүр уруу авто замуудад байршуулах 25 ширхэг давсны савыг засварлан бэлтгэж, цас цэвэрлэгээний ажилд давс бодис цацах, цас түрэх, хусалт хийх 36 техник хэрэгслийн бэлтгэл ажлыг бүрэн хангасан.		100
	Үүрэг даалгавар ЗУРГАА. 2024 оны өвөл дулааны шугам нь доголдож халаалтгүй болсон сургууль, цэцэрлэгүүдийн талаарх мэдээллийг боловсруулан танилцуулах.		
6	2024 онд халаалтын доголдлоос шалтгаалан үйл ажиллагаа нь зогссон сургууль, цэцэрлэг байхгүй. Чингэлтэй дүүргийн 139 дүгээр сургууль, цэцэрлэгийн цогцолборын цэвэр усны гадна шугам цоорсон асуудлыг тухайн үед шуурхай шинэчлэн засварлаж, хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. Мөн халаалтын шугам доголдож болзошгүй, сантехникийн засвар үйлчилгээ хийх шаардлагатай,		100

	өвөлжилт хүндэрч болзошгүй сургууль, цэцэрлэгийн судалгаа, мэдээллийг нэгтгэн боловсруулж, Нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн.			
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ				81,6%



ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

О.БАТМӨНХ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

М.НАВЧАА

НЭГТГЭЖ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.ХУЛАН